



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 110

Мандалговь

**Хөрөнгө акталж, данснаас хасах,
балансаас балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2018 оны 13-07-016/145 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 492,801 /дөрвөн зуун ерэн хоёр мянга найман зуун нэг/ төгрөгийн балансын үнэтэй, 369,601 /гурван зуун жаран есөн мянга зургаан зуун нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 1980 онд ашиглалтанд орсон Өвс тэжээлийн агуулахын барилгыг нэгдүгээр хавсралтын дагуу үнэ тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, 24,815,268 /хорин дөрвөн сая найман зуун арван таван мянга хоёр зуун жаран найм/ төгрөгийн балансын үнэтэй, 2,714,518 /хоёр сая долоон зуун арван дөрвөн мянга таван зуун арван найм/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хоёрдугаар хавсралтад дурдсан хөрөнгийг акталж данснаас хасах, 21,812,396 /хорин нэгэн сая найман зуун арван хоёр мянга гурван зуун ерэн зургаа/ төгрөгийн балансын үнэтэй, 14,987,161 /арван дөрвөн сая есөн зуун наян долоон мянга нэг зуун жаран нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй гуравдугаар хавсралтад дурдсан хөрөнгийг Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургууль, Адаацаг сумын Хүүхдийн цэцэрлэгт балансаас балансад шилжүүлэхийг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Уранцэцэг/, Адаацаг сумын ЕБС-ийн түр орлон гүйцэтгэгч /Б.Даваажаргал/, Адаацаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч /Э.Батцэцэг/ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх


2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дүгээр сарын
13 өдрийн 10 тогтоолын нэгдүгээр хавсралт



Адаацаг сумын ЗДТГ-ын үнэ тогтоон нээлттэй дуудлага
худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлагаар худалдах доод үнэ
1	Өвөр ург өвс гэжээлийн агуулах	ш	1	492,801	123,200	369,601	500,000
	Нийт дүн			492,801 /дөрвөн зуун ерэн хоёр мянга найман зуун нэг/	123,200 /нэг зуун хорин гурван мянга хоёр зуу/	369,601 /гурван зуун жаран есөн мянга зургаан зуун нэг/	500,000 /таван зуун мянга/

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дүгээр сарын
13 өдрийн 10 тогтоолын гуравдугаар хавсралт

Адаацаг сумын ЗДТГ-ын балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлж авах байгууллага
1	Сургуулийн худаг	2008.12.01	ш	1	6,589,800	3,211,690	3,648,109	Адаацаг сумын ЕБС
2	Гүний худаг цэцэрлэг	2014.12.08	ш	1	14,952,596.50	3,613,544.18	11,339,052.32	Адаацаг сумын Хүүхдийн цэцэрлэг
	Нийт дүн				21,812,396.50 /хорин нэгэн сая найман зуун арван хоёр мянга гурван зуун ерэн зургаа/	6,825,234.97 /зургаан сая найман зуун хорин таван мянга хоёр зуун гучин дөрөв/	14,987,161.53 /арван дөрвөн сая есөн зуун наян долоон мянга нэг зуун жаран нэг/	

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 13 дугаар сарын
13 өдрийн 112 тогтоолын хоёрдугаар хавсралт

Адаацаг сумын ЗДТГ-ын акталж, данснаас хасах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Зориулалт	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуриртлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Арилий ухаа 2-р баг	Худаг	1970.04.05	ш	1	1,026,896.94	1,026,896.94	
2	Хужирын цагаан толгой	Худаг	2006.10.16	ш	1	2,299,789	1,379,873.31	919,915.69
3	Цагаан толгой худаг 3-р баг	Худаг	1983.04.21	ш	1	1,827,849.78	1,827,849.78	
4	Зүүн ус э/у худаг 3- р баг	Худаг	1984.06.12	ш	1	5,352,491.70	5,352,491.70	
5	Харуулт худаг 4-р баг	Худаг	1980.10.15	ш	1	5,003,332.20	5,003,332.20	
6	Гүнзгий хур э/у худаг 5-р баг	Худаг	1975.06.21	ш	1	4,536,791.10	4,536,791.10	
7	Луультийн гүнзгий э/у 4-р баг	Худаг	2006.10.16	ш	1	2,457,048	1,586,843.50	870,204
8	Дөрвөлжин э/у худаг 3-р баг	Худаг	2006.10.16	ш	1	2,311,070	1,386,642.04	924,427.96
	Нийт дүн					24,815,268 /хорин дөрвөн сая найман зуун арван таван мянга хоёр зуун жаран найм/	22,100,720 /хорин хоёр сая нэг зуун мянга долоон зуун хорь/	2,714,548 /хоёр сая долоон зуун арван дөрвөн мянга таван зуун дөчин найм/